



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 2/56

Аварга

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хуучин хогийн цэгийг булах, дарах, шинээр хогийн цэг байгуулах ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	-Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	-Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Гишүүдэд	-Байгаль хамгаалагч
	-3-р багийн Засаг дарга
	-4-р багийн Засаг дарга

2.Санхүүжилтээр хийгдэж буй ажлыг баталгаажуулж холбогдох материалыг бүрдүүлж тайланг актаар хүлээн авахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА

Э.ТӨГӨЛДӨР

